

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН “САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

УЛААНБААТАР ХОТ

2026 ОН

НЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Тусгагдсан зохицуулалттай уялдан зардал үүсгэх болон үүсгэж болзошгүй зүйл, заалтыг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу судлалаа.

ХОЁР. УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон баталснаар Улсын төсвөөс аливаа зардал гарахгүй бөгөөд “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон баталснаар Монгол Улс нь Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газраас зээл авах үүрэг хүлээхгүй болно.

Харин тус “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн тусгайлсан Зээлийн хэлэлцээрийг байгуулж, Зээлийн хэлэлцээрийн хүрээнд ашиглалт гарсан тохиолдолд тус ашиглалт нь Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн хэмжээнд багтах бөгөөд Зээлдэгч болох Монгол Улсын Засгийн газрын зүгээс өрийн үйлчилгээнд Зээлийн хэлэлцээрт заасны дагуу төлбөр, шимтгэл төлөхөөр байгаа тул өрийн үйлчилгээнд төлөх төлбөрийг дараах нөхцөлийн дагуу тооцооллоо.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд Австрийн талаас дараах нөхцөлтэй зээлийн эх үүсвэрийг санал болгож байна:

Зээлийн хүү: 1 хувийн хүүтэй,

Баталгааны шимтгэл: 0.9 хувийн баталгааны шимтгэлтэй,

Эргэн төлөх хугацаа:19 жилийн хугацаатай, үүнээс эхний 4 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй болно.

“Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл бүр дээр тусгайлсан зээлийн хэлэлцээрүүд байгуулах бөгөөд тухайн хэлэлцээрийн хүрээнд өрийн үйлчилгээ хийгдэнэ.

Төсөл тус бүр дээр гарах ашиглалтыг урьдчилсан байдлаар тооцон эргэн төлөлтийн хуваарийг тооцсон тул төсөл хэрэгжих хугацаанд төлбөр өөрчлөгдөх магадлалтай.

Хүснэгт 1. Эргэн төлөлтийн хуваарь /евро/.

| Жил | Хагас жил | Зээлийн үлдэгдэл | Ашиглалт | Үндсэн төлбөр | Хүүгийн төлбөр |
|------|-----------|------------------|---------------|---------------|----------------|
| 2027 | 1 | - | 13,700,000.00 | - | - |
| | 2 | 13,700,000.00 | 13,700,000.00 | - | 130,150.00 |
| 2028 | 3 | 27,400,000.00 | 17,525,000.00 | - | 260,300.00 |
| | 4 | 44,925,000.00 | 17,525,000.00 | - | 426,787.50 |
| 2029 | 5 | 62,450,000.00 | 1,275,000.00 | - | 593,275.00 |
| | 6 | 63,725,000.00 | 1,275,000.00 | - | 605,387.50 |
| 2030 | 7 | 65,000,000.00 | - | - | 617,500.00 |
| | 8 | 65,000,000.00 | - | - | 617,500.00 |
| 2031 | 9 | 65,000,000.00 | - | 2,166,666.67 | 617,500.00 |
| | 10 | 62,833,333.33 | - | 2,166,666.67 | 596,916.67 |
| 2032 | 11 | 60,666,666.67 | - | 2,166,666.67 | 576,333.33 |
| | 12 | 58,500,000.00 | - | 2,166,666.67 | 555,750.00 |
| 2033 | 13 | 56,333,333.33 | - | 2,166,666.67 | 535,166.67 |
| | 14 | 54,166,666.67 | - | 2,166,666.67 | 514,583.33 |
| 2034 | 15 | 52,000,000.00 | - | 2,166,666.67 | 494,000.00 |
| | 16 | 49,833,333.33 | - | 2,166,666.67 | 473,416.67 |
| 2035 | 17 | 47,666,666.67 | - | 2,166,666.67 | 452,833.33 |
| | 18 | 45,500,000.00 | - | 2,166,666.67 | 432,250.00 |
| 2036 | 19 | 43,333,333.33 | - | 2,166,666.67 | 411,666.67 |
| | 20 | 41,166,666.67 | - | 2,166,666.67 | 391,083.33 |
| 2037 | 21 | 39,000,000.00 | - | 2,166,666.67 | 370,500.00 |
| | 22 | 36,833,333.33 | - | 2,166,666.67 | 349,916.67 |
| 2038 | 23 | 34,666,666.67 | - | 2,166,666.67 | 329,333.33 |
| | 24 | 32,500,000.00 | - | 2,166,666.67 | 308,750.00 |
| 2039 | 25 | 30,333,333.33 | - | 2,166,666.67 | 288,166.67 |
| | 26 | 28,166,666.67 | - | 2,166,666.67 | 267,583.33 |
| 2040 | 27 | 26,000,000.00 | - | 2,166,666.67 | 247,000.00 |
| | 28 | 23,833,333.33 | - | 2,166,666.67 | 226,416.67 |
| 2041 | 29 | 21,666,666.67 | - | 2,166,666.67 | 205,833.33 |
| | 30 | 19,500,000.00 | - | 2,166,666.67 | 185,250.00 |
| 2042 | 31 | 17,333,333.33 | - | 2,166,666.67 | 164,666.67 |
| | 32 | 15,166,666.67 | - | 2,166,666.67 | 144,083.33 |
| 2043 | 33 | 13,000,000.00 | - | 2,166,666.67 | 123,500.00 |
| | 34 | 10,833,333.33 | - | 2,166,666.67 | 102,916.67 |
| 2044 | 35 | 8,666,666.67 | - | 2,166,666.67 | 82,333.33 |
| | 36 | 6,500,000.00 | - | 2,166,666.67 | 61,750.00 |
| 2045 | 37 | 4,333,333.33 | - | 2,166,666.67 | 41,166.67 |
| | 38 | 2,166,666.67 | - | 2,166,666.67 | 20,583.33 |

| | | | |
|-------------|----------------------|----------------------|----------------------|
| НИЙТ | 65,000,000.00 | 65,000,000.00 | 12,822,150.00 |
|-------------|----------------------|----------------------|----------------------|

- Зээлийн хүүгийн төлбөрийг ашигласан зээлийн дүнгээс тооцож төлөх бөгөөд 65.0 сая еврогийн **эх үүсвэрт баталгааны шимтгэлтэй хамт жилийн 1.9 хувийн хүү** төлнө. Хэлэлцээрийн хүрээнд нийт 12.8 сая еврог хүүгийн төлбөрт төлөхөөр байна.

- БНАУ-тай хэрэгжүүлэх төслүүд нь тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах төсөл тул 2-3 жилийн хугацаанд ашиглахаар тооцсон бөгөөд зээлийн хөрөнгийг 2029 онд бүрэн ашиглаж дуусахаар байна.

ГУРАВ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд хуулийн этгээдэд шууд үүрэг бий болгосон заалт агуулаагүй тул аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй байна.

ДӨРӨВ. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд иргэнд шууд үүрэг бий болгосон заалт агуулаагүй тул аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй байна.

ТАВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон баталснаар Улсын төсвөөс аливаа зардал гарахгүй.

Харин “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүд бүрэн хэрэгжиж дуусах үед зээлийн эх үүсвэрээр худалдан авсан тоног төхөөрөмжийг улсын болон орон нутгийн өмчид шилжүүлэн ашиглалтад хүлээн авах үед:

- Тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал (эрчим хүч, засвар үйлчилгээ),
- Хүний нөөцийн зардал зэрэг зардал улсын төсөвт тодорхой хэмжээний нэмэлт ачаалал үүсгэнэ.

ЗУРГАА. ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙГ ШАЛГАЖ, ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

Зардлын тооцооноос дүгнэхэд хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор иргэн, хувийн хэвшилд нэмэлт зардал гарахгүй ба одоо хэрэгжиж буй хууль, тогтоомж, төрийн байгууллагуудын чиг үүргийн хүрээнд шаардлагатай зохицуулалтууд хийгдэх боломжтой.

оОо